



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/006/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545
Ховд хот	Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
2026 он	Аудитор: Д.Нямгарав Утас: 70432545 Цахим хаяг: nyamgaravd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Зөвлөмж.....	10
4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.28 № 267
танай _____ -ны № _____ -т

ДУУТ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Д.БАТСҮХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд аймгийн Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дуут сум нь 2025 онд малын тоо толгойгоор 90146 мал тоолуулсан нь Ховд аймгийн нийт 3.1 сая малын 2.8 хувийг эзэлж байна. Харин хүн амын өсөлт шилжилт хөдөлгөөнөөр урьдчилсан байдлаар 3783 хүн амтай байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 20 арга хэмжээний зардалд 1,910.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1,883.8 сая төгрөгийг зарцуулснаас 1,618.4 сая төгрөгийг урсгал зардалд, 265.4 сая төгрөгийг ОНХС-ийн шилжих болон шинээр эхлэх 20 хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дуут сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 393.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 52.8 сая төгрөгөөр буурсны 20.5 сая төгрөг нь сумын ангийн

8426050655

орлогын төлөвлөгөөг аймгийн Байгаль орчны газрын хүсэлтээр өөр сумын орлогын төлөвлөгөө рүү шилжүүлснээр, үлдсэн 32.3 сая төгрөг нь малын тоо толгойн албан татвар тасарсантай холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Дуут сумын Хоршоо хөгжүүлэх сангаас эргэн төлөлтийн зээлтэй холбоотой 500.0 мянган төгрөгийн алдангийг цаг тухай бүр тооцон авлагын дансанд бүртгээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	517,921.73	519,718.12
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	247,156.7	222,979.35
3	1.1.3 АВЛАГА	191,092.83	197,339.81
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	46,647.7	36,877.66
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	33,024.5	62,521.3
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,035,982.02	2,107,331.43
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,035,982.02	2,107,331.43
8	1.2.2.02 Биет хөрөнгө	1,903,612.02	1,974,961.43
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	132,370	132,370
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,553,903.75	2,627,049.55
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,274.81	63,087.96
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,274.81	63,087.96
13	2.1.1.03 Өглөг	4,274.81	63,087.96
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,549,628.94	2,563,961.59
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	2,549,628.94	2,563,961.59
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	876,858.14	876,858.14
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	1,429,813.32	1,444,145.98
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	242,957.48	242,957.48
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,553,903.75	2,627,049.55

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,151,204	2,134,786.49
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	455,462.94	392,773.08
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	337,063.72	329,805
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	350,438.96	355,486.49
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-13,375.24	-25,681.49
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	70,163.76	40,920.76
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	48,235.46	22,047.33
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	238,446.94	1,742,013.41
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,263,019.73
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,457,294.11	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,871,241.4	2,134,499.21

12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,871,241.4	1,750,720.01
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,832,197.9	1,692,794.7
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	679,305.06	817,468.5
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,907.71	102,448.12
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	364,621.89	510,165.09
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	346,912.39	31,705.68
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	945.9	600
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	12,911.14	13,782.95
20	1.1.2.01.1.07 Төмилөлт, зочны зардал	7,808.7	8,330
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	168,755.85	45,408.35
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	165,029.26	162,886.02
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,043.5	57,925.31
24	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	383,779.2
25	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	279,962.6	287.28
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	279,962.6	287.28

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,949,908.69	1,895,615.43
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	455,462.94	392,773.08
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	337,063.72	329,805
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-13,375.24	-25,681.49
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	70,163.76	40,920.76
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	48,235.46	22,047.33
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,468.1	4,128.9
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	4,523.36	5,208.26
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	33,244	12,710.17
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,151.64	1,502,842.35
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	37,151.64	29,417.31
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,263,019.73
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	210,405.3
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,457,294.11	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,388,782.1	1,594,775.65
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,388,782.1	1,594,775.65
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,349,738.6	1,536,850.34
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	677,518.53	816,768.28

19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,787.1	107,789.2
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	470,184.14	506,922.17
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	24,648.45	17,592.75
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	546.8	600
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	11,204	9,551.1
24	1.1.1.2.01.1.07 Төмилөлт, зочны зардал	7,808.7	8,330
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,727.21	35,083.23
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	38,313.67	34,213.61
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,043.5	57,925.31
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	561,126.59	300,839.78
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	450,469.7	324,867.12
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	450,469.7	324,867.12
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	450,469.7	324,867.12
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-450,469.7	-324,867.12
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150	150
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-150	-150
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	110,506.89	-24,177.35
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	136,649.81	247,156.7
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	247,156.7	222,979.35

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,261,279.95	2,261,279.95
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,386.39	8,386.39
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,269,666.34	2,269,666.34
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	279,962.6	279,962.6
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,549,628.94	2,549,628.94
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,549,628.94	2,549,628.94
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	14,045.37	14,045.37
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,563,674.31	2,563,674.31
9	1.7 Тайлант үеийн үр дүн	287.28	287.28
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,563,961.59	2,563,961.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,910,051.0	1,883,812.9
11	3.1.01.1.1 Татварын орлого	446,673.2	392,772.8
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	305,595.0	329,804.9
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	331,276.5	355,486.4
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	377,914.70	451,069.46
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	18,000.10	42,964.25
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	50,000.00	37,388.06
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	-	60.12
110008	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	67,500.00	58,220.20
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(25,681.5)	(25,681.5)
110101	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(33,512.60)	(33,512.60)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	90,990.5	40,920.7
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	17,077.7	8,881.1
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,790.0	4,128.9
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	7,287.7	4,752.2
	Байгалийн нөөц ашигласны төлбөр	33,010.00	12,710.10
	Газрын дуудлага худалдаа		456.00
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,463,377.8	1,491,040.1
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	1,755.0	29,417.3
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	1,251,217.50	1,251,217.50
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	210,405.3	210,405.3
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,117,022.5	1,909,598.4
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,614,005.2	1,584,581.3
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,593,607.9	1,526,656.0
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	862,744.2	816,768.2
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,999.1	107,789.2
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	511,559.0	506,922.1
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	19,241.2	17,065.6
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.2	600.0
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	13,200.0	9,551.1
2107	3.1.01.2.1.1.7 Томилот, зочны зардал	9,316.4	8,330.0
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,945.1	34,125.9
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	25,919.7	25,503.9
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,397.3	57,925.3
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	502,867.3	324,867.1
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150.0	150.0
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	206,971.5	(25,785.5)
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	242,801.8
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	217,016.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	11,802.2
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,802.2
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	11,802.2
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	11,802.2
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	11,802.2
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	306.0
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	957.3
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,538.9
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,839.2
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	5,839.2
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,839.2
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	527.1
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	957.3
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	4,354.8
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	5,963.0
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(5,963.0)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(5,963.0)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 34,218.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 552.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Тус суманд хогийн цэг булшлах хөтөлбөр арга хэмжээг Эх нутгийн уулс ХХК нь 2023 онд санхүүжилтийг авч авлага дансанд тусгасан байсныг 2025 онд үндсэн баримтгүй авлага бууруулсан,
- Сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд олгосон 6 иргэний зээлийн эргэн төлөлтөнд хүүгийн алданги тооцоогүй.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 33,665.8 мянган төгрөгийн зөрчлөөс материаллаг бус алдааг үнэлэн тогтоосон ерөнхий материаллаг байдлын түшингээс материаллаг алдаа нь “бага” байгаа өргөн цар хүрээг хамраагүй, материаллаг бус алдаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

¹ Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна

Аудитаар нийт 33,665.8 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Орон нутгийн хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр болон цаг үеийн холбогдолтой шууд зардал болох тэмцээн уралдаан, сар шинийн золголт, сургалт гэх мэт зардлыг орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 13 дугаар зүйлийн 13.5-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ", 13.6-д "Иргэдээс санал авч дэмжигдсэн тохиолдолд Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг дэмжих болон иргэдэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд тоног төхөөрөмжийн болон арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн сургалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж болно", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалт нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллан төсвийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулахыг таслан зогсоож, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажиллах.

3.1.2 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт болон хүү, алдангийн тооцоог тухай бүр тооцдоггүй, түүнд тавих дотоод хяналт сул байгаа нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 тоот тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д "Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр үнэлнэ", 7.4-д "Хяналтын зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавихдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ" гэсэн заалт нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн журмын дагуу зээлийн эргэн төлөлт, хүү алдангийн тооцоог бүрэн хийж барагдуулан, хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус суманд хогийн цэг булшлах хөтөлбөр арга хэмжээг Эх нутгийн уулс ХХК нь 2023 онд санхүүжилтийг авч авлага дансанд тусгасан байсныг 2025 онд үндсэн баримтгүй авлага бууруулсан	1	52.0			1	52.0	1	52.0	-	-
Тус сангаас 2023 онд олгосон 6 иргэний зээлийн эргэн төлөлтөд хүүгийн алданги тооцоогүй	1	500.7	1	500.7			1	500.7		
Дүн	2	552.7	1	500.7	1	52.0	2	552.7		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт болон хүү, алдангийн тооцоог цаг тухай бүр тооцоогүй, түүнд тавих дотоод хяналт сул	1	3,665.8					1	3,665.8
Дүн	1	3,665.8					1	3,665.8

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр болон цаг үеийн холбогдолтой шууд зардал болох тэмцээн уралдаан, сар шинийн золголт, сургалт гэх мэт зардлыг Орон нутгийн сангаас зарцуулсан	1	30,000.0					1	30,000.0

*Дуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан*

Дүн	1	30,000.0						1	30,000.0
------------	----------	-----------------	--	--	--	--	--	----------	-----------------

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	ОНХСан	1		1					
3	ХХСан	1		1					
	НИЙТ	3	1	2			1		